

## **АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам” , Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчныг хамгаалах хуулийн дагуу уурхайн үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдал болон химийн бодисын сав баглаа боодлыг БОАЖЯ-наас олгосон тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжид шилжүүлэх шаардлагатай байдаг.

### **Гүйцэтгэгч байгууллагад тавигдах ерөнхий шаардлага:**

- Гүйцэтгэгч байгууллага нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгосон Аюултай хог хаягдал болон химийн сав баглаа боодлыг тээвэрлэх, дахин боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий гэрчилгээтэй байна.
- Гүйцэтгэгч байгууллагад захиалга өгснөөс 7 хоногийн дотор тээвэрлэлтийг хийж гүйцэтгэнэ.
- Аюултай хог хаягдал тээвэрлэгч нь тусгай тоноглогдсон, аюулгүй байдлыг бүрэн хангасан “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээ бүхий тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр Өмнөговь аймгийн Цогтцэций сумд байрлах салбараас тээвэрлэлт хийнэ.
- Гүйцэтгэгч байгууллага нь тээвэрлэсэн аюултай хог хаягдлыг өөрсдийн тусгай зөвшөөрөл бүхий дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ.
- Аюултай хог хаягдлыг шилжүүлэн авах нэгжийн үнэ болон дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлэх бүх зардлыг оролцуулан тооцно.
- Захиалагч байгууллагаас гарч буй аюултай хог хаягдлын нэр төрөл, тоо хэмжээнээс хамааруулан жилд 1-2 удаагийн тээвэрлэлт хийнэ (жич: аюултай хог хаягдлын гарц бага байдаг).
- Тээвэрлэлт хийх үед 2 талаас хог хаягдлыг шилжүүлэн өгсөн тухай акт үйлдэж баталгаажуулна.